

ЗҮҮН ХОЙТ АЗИЙН БҮС НУТГИЙН ХАМТЫН АЖИЛЛАГАА

*Б.Балдоо**

Ази, Номхон далайн өргөн удам бүс нутгийн /регионы/ нэгэн дэд бүс нутаг /субрегион/ нь Зүүн хойт Ази юм.

Ази тивийн Номхон далайд гарштай зүүн эргийн улс орнууд газар зүйн хувьд зүүн хойт, зүүн, зүүн өмнөд, өмнөд гэх зэрэг хэсгүүдэд хуваагддаг. Эдгээр хэсгийн улс түмний дотор хоёрдугаар дайн, ялангуяа хүйтэн дайнаас хойших жилүүдэд регионализмын үзэл санаа түгэж нутаг орнуудаа бүсчилэн хөгжүүлэхийг эрмэлзсэн алхмууд хийгдэх болжээ. Тухайлбал, Зүүн өмнөд Азийн таван орон 1967 онд “Зүүн өмнөд Азийн орнуудын /үндэстний/ холбоо” /Association of South-East Asian nations/ ASEAN-ийг байгуулав. Өмнөд Азийн долоон орон 1985 онд “Өмнөд Азийн бүсийн хамтын ажиллагааны холбоо” /South Asian Association for Regional Cooperation/ SAARC-ийг байгуулав. Ази тив ба Номхон далайн сав газрын 12 орон 1989 онд “Ази, Номхон далайн эдийн засгийн хамтын ажиллагаа” /Asia Pacific Economic Cooperation/ АПЕС-ийг /форумыг/ байгууллаа. Дурьдсан байгууллагуудын гишүүнд тооцогдсон орнууд өөр өөрсдийн бүс нутагтаа эдийн засгийн салбарт хамтран ажиллах болж, хоорондоо нэгдэн интеграцчилах үйл явц өрнөж эхэлсэн байна.

Гэтэл энэ цаг үед Ази тив, Номхон далайн зүүн хойт хэсэгт интеграцийн үйл явц хараахан үүсээгүй байлаа. Тэгэхэд энэ хэсгийн улс орнууд улс төр-эдийн засгийн өөр өөр системд харьяалагдаж, бие биенийнхээс ялгаатай үзэл суртал баримталж, дэлхийд өөрсдийг нээх асуудалд харилцан адилгүй хандаж байсны дээр эдийн засаг, аж ахуйн хөгжил нь янз бүрийн төвшинд оршиж, хоорондын нь маргааныг төрүүлдэг асуудал ч цөөнгүй байсан юм.

Энэхүү удам их нутаг дэвсгэр нь өөрийн онцлогтой байлаа. Хүн амын нэн олноор, байгалийн нөөцийн их баялгаар,

* Б.Балдоо - ОУСХ-ийн эрдэм шинжилгээний тэргүүлэх ажилтан, академич

соёлын үнэт чухал өв уламжлалаар бусад нутаг дэвсгэрээс ялгагдах шинжтэй байв. Энэ бүс нутагт Хятад, Орос, Япон, мөн түүнчлэн АНУ зэрэг дэлхийн их гүрнүүд зэрэгцэн оршиж байдаг тул энд их гүрнүүдийн бодлого огтлолцож, харилцан үйлдэл нь түүхийн үе шатанд янз бүрээр өрнөж байв. Түүхийн үүднээс үзвэл тэдний газар зүйн байршил, тухайлбал ойр дөт байдал нь тэдгээрийн хооронд харилцааны нягт хэлхээ холбоо тогтон хадгалагдахад тус дэм үзүүлж байсан нь илт. Гэвч улс төрийн барьер, үзэл суртлын ялгааны улмаас сүүлийн тавь шахам жилд энэ харилцаа хүсүүштэй хэмжээгээр, таатай сайн өрнөлгүй явж иржээ.

80-аад оны сүүлчээс хүйтэн дайн төгсөх тийшээ хандаж, их гүрнүүдийн бодлогод өөрчлөлт орж, улс орнуудын харилцаа хэвийн болох хандлага үзэгдэх болсон байна. ЗХУ-д 80-аад оны сүүлчээр гарсан “владивостокийн” ба “красноярскийн” санаачилгын үр дүнд ЗХУ ба бүсийн улсуудын харилцаа аажим сайжрах чигт өөрчлөгдөж, энэ их гүрний дорнодын бодлого нь Ази тивд болон түүний зүүн хойд хэсэгт улс төрийн уур амьсгалыг эрүүлжүүлэх, улс орнуудын хооронд хамтын ажиллагааг тогтоон өрнүүлэхэд түлхэц болсныг үйл явдал харууллаа.

Зүүн хойт Азийн улс орнуудын нийгмийн ба улс төрийн байдалд гарсан өөрчлөлтүүдийн ачаар улс төр, эдийн засаг, соёл зэрэг амьдралын янз бүрийн салбарт улс хоорондын солилцоог шинэтгэн хөгжүүлэх, бие биенээс ялгаатай улс гүрнүүдийг хооронд нь ойртуулах шинэ бололцоо гарч эхлэв.

Ийм бололцоо нээгдэх үед дэлхийн эдийн засгийн гол хүрээнүүдэд аугаа их интеграцийг зүглэсэн саяханы хандлага Азийн зүүн хойт районд оршиж байсан улсуудад нөлөөлж үлгэр загвар болох болсон. Үүний хамт энэ районы улсуудын дотоодод эдийн засгаа шинэтгэн хөгжүүлэх үзэл санаа газар авч олон нийтийн, ялангуяа удирдах хүрээнийхний санаа бодлыг эзэмдэх болсон. Ийнхүү Ази тив, Номхон далайн умард хэсгийн орнууд дэлхийд өргөн түгэж эхэлсэн регионализмын үзэл санааг мөн л бусад бүс нутгийн орнуудын адил тусган авч, тэдний бүсчилэн нэгдэх нутаг дэвсгэр бол Зүүн хойт Ази юм гэдгийг мэдрэх болсон ажээ. Энэ бүхнээс ургуулан хэлэхэд наяд оны төгсгөлөөр дээд цэгтээ хүрч байсан дэлхий дахины нийгэм улс төрийн драматик өөрчлөлтүүд нь “удаан үл анзаарагдсан Зүүн хойт Азийн бүс нутгийн эдийн засгийн хамтын ажиллагааны тухай”¹ өргөн бөгөөд дорвитой бодож

сэтгэх шинэ бололцоог бий болгожээ.

Зүүн хойд Азийн бүс нутаг. Чанчуны бага хурал. Ийм нөхцөлд хорьдугаар зууны сүүлчийн арван жил болон түүнээс цааших хугацаанд Зүүн хойт Азийн бүс нутгийн /ЗХАБН/ эдийн засгийн хамтын ажиллагаа хөгжих бололцоо, тохиолдож болох улс төрийн ба бусад бэрхшээл сааднуудын талаар өргөн судалгаа хийж, хэлэлцүүлэг явуулах нь цаг үеийн тулгамдсан хурц асуудал болсон байна. Ийнхүү Зүүн хойд Азийн эдийн засгийн хамтын ажиллагааны асуудал судлаач-шинжээчдийн анхаарал татсан сэдэв болов. Олон улсын судалгааны энэ чиглэлд анхдагчийн үүргийг АНУ-ын Гавайн арал дахь Гонолулу хотын Дорно-Өрнө төв /ДӨТ/ гүйцэтгэв.

Засгийн газрын санхүүжилтээр үйл ажиллагаагаа явуулдаг Дорно-Өрнө төв АНУ-аас Дорнын, ялангуяа Ази, Номхон далайн орнуудтай тогтоосон холбоо хэлхээ, ялангуяа эдийн засгийн харилцааг судалдаг шинжилгээний байгууллага байсны хувьд бие даан бүс нутаг болох замд гарсан Зүүн хойт Азийг сонирхох болсон нь зүй ёсны зүйл байсан биз. ДӨТ наяд он сүүлч, ерээд оны эхээр ЗХАБН-ийн Япон, Орос, Хятад зэрэг улсуудын улс төрчид, судлаач-шинжээчидтэй хамтран бүс нутагт судалгааны ажлыг эхэлжээ.

ДӨТ-ийн ерөнхийлөгч Др. Ли Жэй Чо Японы гадаад харилцааны сайд асан О.Сабуротай хамтран 1988 онд Япон тэнгисийн асуудлаар Ниигата хотод бага хурал зохиожээ. ДӨТ ЗХУ-ын ШУА-ийн Алс дорнодын салбарын хүрээлэнгүүд, Приморийн хязгаарын захиргаатай хамтран 1989 онд Япон тэнгис, Охотскийн тэнгисийн асуудлаар Владивосток, Находкад уулзалтууд зохиож, улмаар мөн ондоо ЗХУ ГХЯ, ШУА-ийн дэмжлэгтэйгээр “Энх тайван, хамтын ажиллагаа, яриа хэлцэл” сэдэвт бага хурлыг Владивостокт зохион байгуулсан байна.

Энд цохон тэмдэглэхэд Ниигатын бага хурлын үеэр Зүүн хойт Азийн эдийн засгийн хүрээ тойргийн тухай үзэл санаа, Владивостокийн бага хурлын үеэр Түмэн голын сав газарт бүс нутгийн эдийн засгийн хамтын ажиллагааг хөгжүүлэх үзэл санаа анх дэвшигдэн тавигджээ. Яг энэ үеэр Хятадын Шинжлэх ухаан, технологийн улсын комиссын /commission/ дарга Сон Жянь Түмэн голын сав газрыг хөгжүүлэх бололцооны талаар бодолхийлж байсан байна. Тэгээд сэдэгдсэн үзэл санааг хэрэгжүүлэх талаар Ли Жэй

Чо, Сон Жянь нар санаачилга гаргаж 1990 онд БНХАУ-ын Чанчун хотод Зүүн хойд Азийн хөгжлийн асуудлаар анхны бага хурлыг зохион байгуулжээ². АНУ-ын эрдэм шинжилгээний байгууллага, түүний эрдэмтдийн идэвхтэй үйл ажиллагаа, санаачилгатайгаар, ЗХА-ийн улс орнуудын судлаачид, улс төрчдийн оролцоо дэмжлэгтэйгээр Зүүн хойт Азийг бүс нутаг болгож, тэнд бүсийн эдийн засгийн хамтын ажиллагааг хөгжүүлэх нэн ирээдүйтэй үзэл санааг бодит ажил болгох практик алхам 1990 онд ийнхүү хийгдэж, хожмоо НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн бүрэн дэмжлэгийг авсан билээ.

Нэг жилийн дараа буюу 1991 оны наймдугаар сард ДӨТ-өөс БНХАУ-ын Ази, Номхон далайн хүрээлэнтэй хамтран Чанчуны II бага хурлыг зохион байгуулж “Зүүн хойт Азийн эрэг хавийн нутаг дахь эдийн засгийн хөгжил” сэдэв хэлэлцүүлсэн нь ЗХА-ийн эдийн засгийн хамтын ажиллагааны асуудлыг тусгайлан сонгон авч, хэлэлцэж эхэлсэн анхны бага хурал болсон байна. Бага хурлыг Японы Сасакавагийн Энх тайвны сан, Солонгосын Аж үйлдвэрийн эдийн засгийн хүрээлэнгийн санхүүгийн дэмжлэгтэй зохиосон бөгөөд ийнхүү хурал, уулзалтуудыг бүс нутгийн сонирхсон эрдэм шинжилгээ, олон нийт, төрийн байгууллагуудын ивгээл дэмжлэгтэй зохиох явдал уламжлал болон цааш үргэлжилсэн байна. Бага хуралд бүс нутгийн 6 орны болон НҮБ-ийн хөгжлийн хөтөлбөрийн төлөөлөгчид, тэдний дотор Хятадын Зүүн хойт гурван мужийн олон тооны төлөөлөгчид, нийтдээ 100 гаруй хүн оролцсон байна. Хурлаар тэр үед нэн тулгам болж байсан ЗХА-ийн эдийн засгийн хамтын ажиллагааны бааз суурь; Түмэн голыг хөгжүүлэх төсөл, түүний үр ашиг; ЗХУ дахь эдийн засгийн хамтын ажиллагаа, түүний Алс Дорнод; ЗХА дахь далайн нөөц ба хамтын ажиллагаа; Өрнөд Европын туршилт, түүний сургамж гэх зэрэг хэд хэдэн бүлэг багц асуудлаар 12 илтгэл тавьж, 50 хүн өөрийн санал комментарийг хийжээ. Эдгээрээс үзвэл Чанчуны II бага хурлын илтгэлүүд, I бага хурал дээр илэрхийлсэн үзэл санааг урагш хөгжүүлэн гүнзгийрүүлж, альтернативуудыг өргөтгөж, асуудлуудыг ихэд тодруулж, олон орны эрдэмтэд чин бодлын үзэл санаа, ирээдүйд хэрэгжүүлж болохуйц саналууд дэвшүүлсэн ажээ.

Чанчуны бага хурлын дискуссийн төвт байсан: ЗХА-ийг бүсчилэн хөгжүүлэх бололцоо нөхцөлийн тухай, бага хурлаас цаашдын үйл ажиллагаандаа удирдлага болгосон гол үзэл бодол,

зорилтын тухай, ЗХУ дахь эдийн засгийн хамтын ажиллагаа, Түмэн голын сав газрыг бүсийн улсуудын хамтын ажиллагааны нутаг дэвсгэр болгон хөгжүүлэх үзэл санааны тухай, ЗХА-ийн бүс нутгийн эдийн засгийн хамтын ажиллагааны байгууллага байгуулах тухай бага хурлын шийдвэрийн талаар товч дурдъя.

Чанчуны бага хурлаар Ази, Номхон далайн умард хэсгийг Зүүн хойт Азийн бүс нутаг хэмээн тусгайлан авч үзээд тус бүсэд зүүн хойд, баруун хойд, хойд Хятад, Оросын Дорнод Сибирь ба Алс дорнодын район, Умард ба Өмнөд Солонгос, Япон, Монгол улсыг оруулжээ.³ Хоёрдугаар бага хурал “бүс нутгийн харилцан нөхөх чадавхи хийгээд бүс нутгийн дотоодын асар их дагналт дээр суурилсан бүс нутгийн хамтын ажиллагаа нь оролцогч бүх оронд ашиг тус өгнө” гэсэн ерөнхий бодол санааг ноттой дэвшүүлсэн байна. Хамтын ажиллагаанд нэгдэн орсон орон бүр өөрийн эдийн засгийн өсөлтийг нэмэгдүүлэх бололцоо олох бөгөөд үүнийг Зүүн хойт Хятад, Умард Солонгосын ажиллах хүчний нөөцийг Оросын Алс Дорнод ба Монголын байгалийн баялагийн нөөцтэй хослон, Япон ба Өмнөд Солонгосын капитал ба технологийг ашиглан хангаж болно гэж үзжээ.⁴ Ийм хамтын ажиллагаанд үндэслэсэн өсөлтийн динамик үр дагавар нь Японыг оролцуулсан эх газрын Зүүн хойт Азийн өрсөлдөх чадварыг дэлхий дээр нэмэгдүүлнэ гээд энэхүү хамтын ажиллагаа нь цаашид ямар өвөрмөц хэлбэрийг олж болохыг эдийн засгийн нэр томъёогоор илэрхийлэн харуулахын тулд асар их судалгаа явуулах хэрэгтэйг бага хурал хүлээн зөвшөөрсөн байна. Бас Зүүн хойт Азийн хамтын ажиллагаа өөд бие даан урагшилахын тулд нэгдэн орсон улс тус бүр өөрийн эдийн засгийн сувернитетын зарим зүйлээр компромисс буулт хийх улс төрийн хамтын ажиллагаа явуулж, улс төрийн хүсэл зориг гаргах шаардлага гарна гэж үзсэн байна.⁵

Энэхүү ерөнхий зорилтыг хэрэгжүүлэхтэй холбогдуулан тус бага хурал Чанчуны нэгдүгээр бага хурлаас ЗХА-ийн бүс нутгийн эдийн засгийг хөгжүүлэх тодорхой зорилтууд, тухайлбал Түмэн голын сав газрыг хөгжүүлэх талаар гаргасан саналыг дахин нотлов. Тэгээд Япон далайн хүрээ тойрог, Түмэн голын сав газрын асуудлыг тодруулан авч үзжээ.

Түмэн голын сав газрыг бүс нутгийн улсуудын эдийн засгийн хамтын ажиллагааг өрнүүлж болох район гэдгийг нотлоод ингэж тусгайлан авч үзэх хэд хэдэн шалтгаан байгааг тодорхойлжээ.

Үүнд:

- Энэ нь Зүүн хойд Азийн орнуудыг хамтын хүчин чармайлтанд уриалах ач холбогдолтой.

- Энэ нь Хятад, Орос, Солонгосын зохих районудын хөгжилд түлхэц өгч чадна.

- Энэ нь Япон далайг хөвөөлсөн Япон, Өмнөд Солонгосын эрэг хавийн нутгийн хөгжилд тус дэм болно.

- Энэ нь Монгол улсад Зүүн хойд Азийн хамтын ажиллагаанд оролцох бололцоог нээж өгнө гэж үзсэн байна. Тэгээд бага хурал Түмэн голын сав газрыг хөгжүүлэх хэд хэдэн санал дэвшигдсэн байгааг дурдаж, Түмэн голын бага Алтан бэлчээрийн эдийн засгийн чөлөөт бүс, их Алтан бэлчээрийн тусгай бүсийн үзэл санааг тодорхойлсон нь цаашдын чухал ач холбогдолтой болсон байна.⁶

Чанчуны хоёрдахь бага хурлаар “Чанчуны санаачилга” хэмээх баримт бичиг батлаж, судалгааг харилцан холбох, зохицуулах байгууллага байгуулах шийдвэр гаргасан. Тэр баримт бичигт: Чанчуны хоёр бага хурал амжилттай болсон; ЗХА дахь эдийн засгийн хандлага нь мөнхүү нутагт эдийн засгийг хөгжүүлэх, хамтран ажиллах талаархи судалгааны ажлын холбоо хэлхээ болон зохицуулалтыг цаашид үргэлжүүлэх явдал нэн чухал бөгөөд хүсүүшгэй болгосныг; зохицуулах үйл ажил нь институтчлэлийн сүлжээ болон зохицуулалтын механизм бий болгохыг шаардаж байгааг тус тус харгалзан үзээд “Зүүн хойт Азийн эдийн засгийн форум” гэдэг байгууллага байгуулах нь зүйтэй гэж заасан байна.⁷ Энэ форумын зорилго нь Зүүн хойд Азид холбогдох судалгааны ажлыг зохицуулан, дискусси мэтгэлцээнийг зохион байгуулах, Зүүн хойт Ази дахь эдийн засгийн хөгжил ба хамтын ажиллагааны талаар мэдээлэл солилцох явдал хөгжүүлэхэд оршино гэж заав.

Бага хурлын энэхүү санаачилгыг үндэслэн Дорно-Өрнө төв 1992 оны дөрөвдүгээр сард “Зүүн хойт Азийн эдийн засгийн форум” /ЗХА ЭЗФ/ байгууллагыг албан ёсоор байгуулан АНУ-ын Гонолулу хотод төвлөрүүлэхээр тогтжээ.⁸ Энэ үйл явдлын үр дүнд ЗХА-ийн эдийн засгийн хамтын ажиллагааны талаарх “мэдээллийн солилцоо”, “судалгааны зохицуулалтыг” эрхлэн зохион байгуулах бүс нутгийн өөрийн эрдэм шинжилгээний нэгэн чухал байгууллага бий болж, Дорно-Өрнө төвөөс халааг авч үйл ажиллагаагаа өрнүүлж эхэлжээ. 1980-аад оны эцэс, 1990-ээд оны эхээр ЗХА-ийн орнуудад шинэ чиглэлийн судалгааг эрхлэх төрийн,

олон нийтийн, эрдэм шинжилгээний байгууллагууд үүсч ЗХА ЭЗФ байгууллагатай холбоо тогтоон бүс нутгийн хэмжээгээр явагдах мэдээлэл, судалгааны үйлст оролцох боллоо.

Чанчуны бага хурлын үзэл санаа, ДӨТ-ын явуулж эхэлсэн үйл ажиллагааны нөлөөгөөр ЗХА-д эдийн засгийн хамтын ажиллагааг хөгжүүлэх зорилготой шинэ үзэгдэл –“Зүүн хойт Азийн эдийн засгийн форум” байгууллага гараагаа эхэлж ирээдүйн бодит ажлын үндсийг тавих судлан боловсруулах ажилдаа орсон байна.

ИШЛЭЛ

1. NEAEEF Northeast Asia Economic Forum. Promoting Dialogue and Facilitating Research. NEAEEF Secretariat, East-West Center, Honolulu.
2. Northeast Asia Economic Forum. Дурдсан зохиол
3. Proceeding of the Conference on Economic Development in the Coastal Area of Northeast Asia. 29-31 August 1991, Changchun, China, p.95
4. Мөн тэнд р.IX
5. Мөн тэнд р.IX
6. Мөн тэнд р.98
7. Мөн тэнд р.221
8. NEAEEF Northeast Asia Economic Forum. Proceeding of the Conference on Economic Development in the Coastal Area of NEA. Ишилсэн зохиол. р.IX